



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/397

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг сайжруулж, нэн шаардлагатай төрөлжсөн нарийн мэргэжлээр сургах чадавхжуулах зорилгоор Хүүхдийн сэргээн засах төвийн сургагч багш нартай хамтран зохион байгуулах "Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж" сургалтыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т даалгасугай

2.Сургалт зохион байгуулахад шаардлагатай төсөв дэмжлэг үзүүлж 640,000 (зургаан зуун дөчин мянган) төгрөгийг "Эрүүл мэнд" хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3.Сургалтын үр дүн, хамрагдалтад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

